



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/51/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Ахлах аудитор: Д.Алтайбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Загруулсан алдаа	17
4.2 Төлбөрийн акт	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/161
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	48,217,421.67	154,847,829.64
33	АВЛАГА	00.00	53,379,954.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	52,557,400.00
335	Бусад авлага	00.00	822,554.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	822,554.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,217,421.67	101,467,875.64
351	Түүхий эд материал	19,918,192.40	47,482,787.27
35130	Эм боох материал	19,918,192.40	47,482,787.27
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,304,835.21	4,446.01
354	Хангамжийн материал	26,994,394.06	53,980,642.36
35410	Бичиг хэргийн материал	469,900.00	1,664,131.00
35420	Аж ахуйн материал	6,049,108.00	18,058,208.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	1,560,000.00
35440	Түлш, шатах тослох материал	669,148.27	663,402.27
35450	Барилгын засварын материал	00.00	1,412,000.00
35460	Хүнсний материал	2,179,371.79	1,270,175.09
35470	Бусад хангамжийн материал	17,626,866.00	29,352,726.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	560,227,080.84	561,967,693.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	560,227,080.84	561,967,693.23
392	Биет хөрөнгө	531,191,080.84	547,931,693.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	464,398,880.00	464,023,880.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-40,829,440.60	-54,267,149.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,459,238.00	71,739,238.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-18,855,367.07	-27,101,621.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	150,767,299.40	174,425,900.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-105,045,829.57	-95,311,242.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,163,273.00	27,147,932.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,866,972.32	-12,725,244.37
393	Биет бус хөрөнгө	29,036,000.00	14,036,000.00
39301	Програм хангамж	15,550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,036,000.00	14,036,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	608,444,502.51	716,815,522.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	608,444,502.51	716,815,522.87
51	Засгийн газрын хувь оролцоо	608,444,502.51	716,815,522.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	385,375,911.00	385,375,911.00
51101	Өмч: - төрийн	385,375,911.00	385,375,911.00
512	Хуримтлагдсан үр дүн	12,376,502.45	120,747,522.81
51210	Өмнөх үеийн үр дүн	12,376,502.45	12,376,502.45
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	108,371,020.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	210,692,089.06	210,692,089.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	608,444,502.51	716,815,522.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	651,338,848.98	1,130,085,424.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	101,463,728.98	368,429,554.80
120	Нийтлэг татварын бус орлого	101,463,728.98	368,429,554.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	101,463,728.98	368,429,554.80
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	101,463,728.98	368,429,554.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	101,104,420.00	242,331,470.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	448,770,700.00	466,767,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,892,430.00	40,583,780.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	339,800.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	550,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,892,430.00	39,408,130.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	285,350.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,428,100.00	32,937,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,428,100.00	32,937,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	53,783,890.00	168,810,190.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	53,783,890.00	168,810,190.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	614,692,442.91	1,006,714,404.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	614,692,442.91	1,006,714,404.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	607,284,272.71	957,314,404.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	355,969,102.00	394,558,523.00
210101	Үндсэн цалин	355,969,102.00	394,558,523.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,779,100.00	52,846,320.00
210201	Тэтгэврийн даатгал	33,622,300.00	37,717,462.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,539,200.00	3,955,486.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,831,400.00	3,164,388.00
210204	Ажилгүйдлийн даатгал	707,800.00	718,612.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,078,400.00	7,290,372.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,440,217.80	28,940,500.00
210301	Гэрэл, цахилгаан	3,049,160.00	2,700,643.00
210302	Түлш, халаалт	24,053,057.80	25,639,857.00
210303	Цэвэр, бохир ус	1,338,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,893,128.00	58,250,058.00
210401	Бичиг хэрэг	2,994,600.00	4,317,219.00
210402	Тээвэр, шатахуун	23,586,410.00	26,191,989.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,587,668.00	2,060,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,724,450.00	25,680,850.00
2105	Нормативт зардал	71,261,614.27	364,521,728.83
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	61,302,835.77	348,409,365.13
210502	Хоол, хүнс	9,958,778.50	16,112,363.70
2107	Томилолт, зочны зардал	750,300.00	1,234,000.00
210702	Дотоод албан томилолт	750,300.00	1,234,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,901,360.00	2,422,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,361,500.00	1,512,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,000.00	79,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	50,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	26,500.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	394,000.00	208,000.00
210807	Газрын төлбөр	140,360.00	140,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,289,450.64	54,540,914.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,610,050.00	3,709,430.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,679,400.64	50,831,484.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,408,170.20	49,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	49,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	35,900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	13,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,765,340.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,765,340.00	00.00

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,642,830.20	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,642,830.20	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	36,646,406.07	123,371,020.36
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	15,000,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	15,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-15,000,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	36,646,406.07	108,371,020.36

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	385,375,911.00	12,376,502.45	608,444,502.51
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	385,375,911.00	12,376,502.45	608,444,502.51
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	385,375,911.00	12,376,502.45	608,444,502.51
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	108,371,020.36	108,371,020.36
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	385,375,911.00	120,747,522.81	716,815,522.87

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	549,875,120.00	709,098,470.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	549,875,120.00	709,098,470.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	448,770,700.00	466,767,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,892,430.00	40,583,780.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	339,800.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	550,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,892,430.00	39,408,130.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	285,350.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,428,100.00	32,937,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,428,100.00	32,937,500.00

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	53,783,890.00	168,810,190.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	53,783,890.00	168,810,190.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	540,075,120.00	696,428,470.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	540,075,120.00	696,428,470.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	532,666,949.80	647,028,470.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	355,969,102.00	394,558,523.00
210101	Үндсэн цалин	243,939,580.00	245,644,385.00
210102	Нэмэгдэл	98,732,630.00	100,667,146.00
210104	Урамшуулал	13,296,892.00	42,803,826.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	5,443,166.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,779,100.00	52,846,320.00
210201	Тэтгэврийн даатгал	33,622,300.00	37,131,940.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,539,200.00	3,875,098.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,831,400.00	3,136,949.00
210204	Ажилгүйдлийн даатгал	707,800.00	826,159.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,078,400.00	7,876,174.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,440,217.80	28,940,500.00
210301	Гэрэл, цахилгаан	3,049,160.00	2,700,643.00
210302	Түлш, халаалт	24,053,057.80	25,639,857.00
210303	Цэвэр, бохир ус	1,338,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,469,568.00	54,512,697.00
210401	Бичиг хэрэг	1,825,000.00	5,346,450.00
210402	Тээвэр, шатахуун	26,865,500.00	27,008,797.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,737,668.00	2,060,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	165,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	13,745,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,441,400.00	6,187,000.00
2105	Нормативт зардал	41,707,452.00	88,979,430.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,663,452.00	69,991,263.00
210502	Хоол, хүнс	9,544,000.00	16,988,167.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,500,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,039,800.00	16,707,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	3,210,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,595,000.00	9,500,000.00
210604	Урсгал засвар	8,444,800.00	3,997,000.00
2107	Томилолт, зочны зардал	750,300.00	1,234,000.00
210702	Дотоод албан томилолт	750,300.00	1,234,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,901,360.00	3,072,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,361,500.00	2,162,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,000.00	79,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	50,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	26,500.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	394,000.00	208,000.00
210807	Газрын төлбөр	140,360.00	140,360.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	00.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,610,050.00	6,177,640.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,610,050.00	6,177,640.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,408,170.20	49,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	49,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	49,400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,642,830.20	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,642,830.20	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,765,340.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,765,340.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,800,000.00	12,670,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,800,000.00	12,670,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,800,000.00	12,670,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,800,000.00	12,670,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,800,000.00	12,670,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,800,000.00	-12,670,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	555,728,100.0	539,331,390.0	16,396,710.0	97.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	555,728,100.0	539,331,390.0	16,396,710.0	97.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	555,728,100.0	539,331,390.0	16,396,710.0	97.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,923,900.0	362,367,473.0	6,556,427.0	98.2
210101	Үндсэн цалин	247,086,400.0	245,644,385.0	1,442,015.0	99.4
210102	Нэмэгдэл	99,995,700.0	100,667,146.0	-671,446.0	100.7
210104	Урамшуулал	16,801,800.0	10,612,776.0	6,189,024.0	63.2
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.0	5,443,166.0	-403,166.0	108.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,804,700.0	48,878,600.0	926,100.0	98.1
210201	Тэтгэврийн даатгал	35,047,800.0	34,395,700.0	652,100.0	98.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,689,200.0	3,620,700.0	68,500.0	98.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,951,400.0	2,896,400.0	55,000.0	98.1
210204	Ажилгүйдлийн даатгал	737,800.0	724,300.0	13,500.0	98.2
210205	Эрүүл мэндийн даатгал	7,378,500.0	7,241,500.0	137,000.0	98.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,500,000.0	28,940,500.0	2,559,500.0	91.9
210301	Гэрэл, цахилгаан	3,200,000.0	2,700,643.0	499,357.0	84.4
210302	Түлш, халаалт	27,700,000.0	25,639,857.0	2,060,143.0	92.6
210303	Цэвэр, бохир ус	600,000.0	600,000.0	00.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	33,280,000.0	30,096,757.0	3,183,243.0	90.4
210401	Бичиг хэрэг	1,900,000.0	1,846,450.0	53,550.0	97.2
210402	Тээвэр, шатахуун	23,000,000.0	22,065,307.0	934,693.0	95.9

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,050,000.0	1,520,000.0	1,530,000.0	49.8
210404	Ном, хэвлэл	830,000.0	165,000.0	665,000.0	19.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.0	2,500,000.0	00.0	100.0
2105	Нормативт зардал	48,247,500.0	48,247,500.0	00.0	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,097,500.0	32,097,500.0	00.0	100.0
210502	Хоол, хүнс	14,150,000.0	14,150,000.0	00.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,500,000.0	11,497,000.0	3,000.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,500,000.0	6,500,000.0	00.0	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.0	1,000,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	4,000,000.0	3,997,000.0	3,000.0	99.9
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.0	586,000.0	414,000.0	58.6
210702	Дотоод албан томилолт	1,000,000.0	586,000.0	414,000.0	58.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,214,000.0	2,910,360.0	1,303,640.0	69.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.0	400,000.0	00.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	79,000.0	79,000.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.0	50,000.0	00.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.0	33,000.0	7,000.0	82.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.0	208,000.0	292,000.0	41.6
210807	Газрын төлбөр	145,000.0	140,360.0	4,640.0	96.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.0	00.0	1,000,000.0	00.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,258,000.0	5,807,200.0	1,450,800.0	80.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,258,000.0	5,807,200.0	1,450,800.0	80.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	555,728,100.0	539,331,390.0	16,396,710.0	97.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	466,767,000.0	466,767,000.0	00.0	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	466,767,000.0	466,767,000.0	00.0	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,500,000.0	32,937,500.0	2,562,500.0	92.8
132001	Орон нутгийн төсвөөс	35,500,000.0	32,937,500.0	2,562,500.0	92.8
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	53,461,100.0	39,626,890.0	13,834,210.0	74.1
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	53,461,100.0	39,626,890.0	13,834,210.0	74.1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	33.00	33.00	00.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	25.00	25.00	00.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	00.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөг/
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	169,767,080.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	169,767,080.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	120,367,080.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,191,050.00
210104	Урамшуулал	32,191,050.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,967,720.00
210201	Тэтгэврийн даатгал	2,736,240.00
210202	Тэтгэмжийн даатгал	254,398.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	240,549.00
210204	Ажилгүйдлийн даатгал	101,859.00
210205	Эрүүл мэндийн даатгал	634,674.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,415,940.00
210401	Бичиг хэрэг	3,500,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,943,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	540,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,745,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,687,000.00
2105	Нормативт зардал	40,731,930.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,893,763.00
210502	Хоол, хүнс	2,838,167.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,880,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,380,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	648,000.00
210702	Дотоод албан томилолт	648,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	162,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	162,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	370,440.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	370,440.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	49,400,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	169,767,080.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	169,767,080.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	129,183,300.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	339,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	550,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,408,130.00
131106	Төсвийн урамшуулал	285,350.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн Шилэн дансны хууль тогтоомж, Хууль тогтоомжтой холбоотой, Үндсэн хөрөнгө актлахтай холбоотой асуудалд өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ахлах аудитор О.Хосбаяр, аудитор О.Оюунцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, Төгс суурь стандарт аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, гүйцэтгэх захирал Т.Батсайхан нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, ил тод хүртээмжтэй үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгуурлан, ард иргэдэд эрүүл зөв амьдрах дадал үйлийг оновчтой тэгш хүртээмжтэйгээр хүргэж, орон нутгийн иргэдийн дундаж наслалт, амьдралын чадамжийг уртасгах, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулж ажиллах зорилго тавьсан байна.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх
- Сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх
- Сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх оноосон нэрийг өөрчлөх тухай.
- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны 04 сарын 30-ны 67/А/268 дугаар тушаалаар Ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж,

үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай.

- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны А/387/99 журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай.
- “Хөвсгөл аймгийн засаг даргын захирамж” 2021 оны А243 түр журам батлах тухай. Ковид-19-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх түр журмаар баталсан байна.
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын нэгжийг шинэчлэн томилох тухай 2021 оны 11 сарын 09 өдрийн А/4 тушаалаар бүрэлдэхүүнийг шинэчилж 10 чиглэлээр ажлын төлөвлөгөөг баталжээ.

Дотоод хяналтын баг нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайланг удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 466.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 108.4 сая төгрөгөөр буюу 17.8 хувиар

буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг харуулав.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	53.4	53.4
Бараа материал	48.2	101.4	53.2
Биет хөрөнгө	531.2	548.0	16.8
Биет бус хөрөнгө	29.0	14.0	-15.0
Нийт хөрөнгө	608.4	716.8	108.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	608.4	716.8	108.4

Авлагын үлдэгдэл 53.4 сая төгрөг байгаа нь Эрүүл мэндийн даатгалын сангаас Ковид-19 цар тахлын үед иргэдэд үзүүлсэн цогц тусламж үйлчилгээний санхүүжилтийн авлага. Эрүүл мэндийн даатгалтай авлагын тооцоог нийлж баталгаажуулсан.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 53.2 сая төгрөгөөр өсөж 101.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан эм боох материал 69.3 сая төгрөг,
- Эрүүл мэндийн газраас эрх шилжүүлэн авсан вакцин, эм тариа 303.8 сая төгрөг,
- улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан түлш шатах тослох материал 26.2 сая төгрөг,
- Хүнсний материал 15.2 сая төгрөг,
- Бусад хангамжийн материал 19.0 сая төгрөг,
- Иргэний хандиваар 1.2 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсан,
- Нийт 423.8 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Биет хөрөнгийн үлдэгдэл 16.8 сая төгрөгөөр өсөж 548.0 сая төгрөг болсон. Үүнд материаллаг нөлөөтэй биет хөрөнгө:

- Иргэний хандиваар авсан хүчилтөрөгчийн аппарат 0.8 сая төгрөг, принтер 0.4 сая төгрөг,
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 сарын 01-ний өдрийн А/741 тоот тушаалаар “МонПэн” төслийн хүрээнд тавилга, хэрэгсэл, компьютер техник хэрэгсэл 13.6 сая төгрөг,
- Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 07 сарын 27-ны өдрийн А/90 тушаалаар зөөврийн технологи 3.6 сая төгрөг,
- Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 07 сарын 27-ны өдрийн А/91 тушаалаар лабораторийн тоног төхөөрөмж 9.7 сая төгрөг,
- Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 11 сарын 15-ны өдрийн А/16 тушаалаар лабораторийн тоног төхөөрөмж 14.2 сая төгрөг,
- Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 12 сарын 7-ны өдрийн А/148 -р тушаалаар дархлаажуулалтын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж 4.8 сая төгрөг тус тус хүлээн авсан.
- Тайлант хугацаанд Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 12 сарын 21-ний өдрийн 109-р тогтоолоор 20.2 сая төгрөг, Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны 04 сарын 05-ны өдрийн 13-р тогтоолоор 6.9 сая төгрөгийн тавилга тоног төхөөрөмж, нийт 27.5 сая төгрөгийн биет хөрөнгийг данснаас хасаж 4.5 сая төгрөгөөр дахин үнэлж орлогод авсан.

Биет бус хөрөнгийн эцсийн үлдэгдэл 14.0 сая төгрөг болж 15.0 сая төгрөгөөр буурсан. Энэ нь 15.0 сая төгрөгийн “Цахим эрүүл мэнд” программыг акталсантай холбоотой.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 557.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг үнийн дүнгээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсөв захирагч 2021 оны төсвийн төслийг бууруулан 555.7 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Улсын төсвөөс 466.8 сая төгрөг,
- Орон нутгийн төсвөөс 35.5 сая төгрөг,
- Эрүүл мэндийн даатгалын сангаас 53.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх “Эмнэлгийн тусламж үйлчилгээ” хөтөлбөрийг нийт 555.7 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 466.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 32.9 сая төгрөг, ЭМД-ын сангаас 39.6 сая төгрөг авсан байна.

Төсвийн нийт зардлыг төлөвлөснөөс 16.4 сая төгрөгөөр, цалин хөлс нэмэгдэл урамшууллыг 6.5 сая төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 0.9 сая төгрөг, байр ашиглалттай холбогдсон тогтмол зардлыг 2.6 сая төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 3.2 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг дутуу авсантай холбоотой байна.

Тайлант оны төсвийн гүйцэтгэлээр цалин хөлс нэмэгдэл урамшуулалд 362.4 сая төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 48.9 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 28.9 сая төгрөг, хангамжийн бараа материалын зардалд 30.0 сая төгрөг, норматив зардалд 48.3 сая төгрөг, эд хогшил худалдан авахад 11.5 сая төгрөг, томилолтын зардалд 0.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамж зардалд 2.9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 5.8 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагад дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид 39.4 сая төгрөг хуваарилснаас ЭМГ-ын даргын 2021 оны 8 сарын 4-ний өдрийн А/92 тоот тушаалаар 25.1 сая төгрөгийн тэтгэмж урамшууллын зардал, мөн газрын даргын 10 сарын 1-ний өдрийн А/444 тоот тушаалаар 10.8 сая төгрөгийн тэтгэмж урамшууллын зардал, Эрүүл мэндийн даатгалын сангаас Ковидын цогц тусламж үйлчилгээний зардалд 129.2 сая, нийт 169.7 сая төгрөгийг хуваарилсан байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 32.2 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 4.0 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 24.4 сая төгрөг, норматив зардалд 40.7 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 17.9 сая төгрөг, дотоод албан томилолтод 0.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад

нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 0.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 0.4 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал 49.4 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал, үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

- Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан. Ковидын тархалттай холбогдсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ихээхэн нэмэгдсэн. Ковидоор 356 хүн өвчилж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан, дархлаажуулалтаар 6579 тун вакцинд иргэдийг хамруулж нийт 181.6 сая төгрөг нэхэмжилснээс 129.1 сая төгрөгийн санхүүжилт авч 52.5 сая төгрөгийн авлагатай гарсан байна. Авлагыг баталгаажуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн 2021 оны аудитын явцад материаллаг түвшний асуудал илрээгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 хамаарах төсөвт байгууллага төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6-р зүйлийн 6.1-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зориулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 499.7 сая төгрөгийн 119 мэдээллийг оруулахаас 2021 оны 11 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ буюу 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шинэ дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалаар сумдын хүн эмнэлгийг Эрүүл мэндийн төв болгон өөрчилсөн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайланд Ихэр мөрөн аудит ХХК аудит хийж биет ба биет бус үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах, дахин үнэлэх тухай 2019 оны 271-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах 3 зөвлөмж өгсний 2 зөвлөмжийг биелүүлсэн байна. Ашиглалтгүй болсон 15.0 сая төгрөгийн анхны өртөгтэй “Цахим эрүүл мэнд” программыг акталж данснаас хасах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх оноосон нэрийг өөрчилсөн эсэхийг хянах.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 15.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 15.0 сая төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хууль тогтоомжтой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.1 хэсэгт заасан 2-р улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаа хоцроож байршуулсан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.1 хэсэгт заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн гүйцэт мэдээлсэн байх зөвлөмж өгөв.

2. Үндсэн хөрөнгө актлахтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Биет бус хөрөнгөөс 15.0 сая төгрөгийн “Цахим эмнэлэг” программыг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр акталсан байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 31 дүгээр зүйлийн 3-т заасан заалтыг баримтлан ажиллах зөвлөмж өгөв.

3.Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.3. Илрүүлэлт:

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалаар сумдын хүн эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон өөрчилж тус тушаалаар дараах тушаалууд хүчингүй болсон байна. Үүнд: Эрүүл мэндийн сайдын Сум дундын эмнэлэг байгуулах тухай 2003 оны 114, Сумдын эмнэлгийн статусыг өөрчлөх тухай 2011 оны 292, Сум дундын эмнэлэг байгуулах тухай 2013 оны 256 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосон байна. Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх оноосон нэрийг өөрчлөөгүй байна.

2.4. Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Улсын бүртгэлийн гэрчилгээнд оноосон нэрийг өөрчлөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын хүн эмнэлэг	3	15.0	-	-	-	-	-	-	3	15.0